

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

## Арилжааны хэлцэл хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.6, Иргэний хуулийн 56.1.1, 107.2, 498.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2, 19.2.8, 27.3.2, 34.1.1 дэх заалт, Үнэт цаасны хорооны 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам”-ын 3.1.1, 3.1.2, 3.1.4, 4.3.3, 4.3.4, 4.3.5, 4.3.9 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөрөнгийн бирж” ХК-ийн 2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 1082 дугаар арилжаагаар “Тахько” ХК-ийн 70 ширхэг хувьцааг арилжаасан 36 дугаар хэлцлийг хүчингүй болгосугай.
2. “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь харилцагчийн 27-63032 тоот дансанд дээрх арилжаагаар арилжигдсан хувьцааг буцаан бүртгэж, иргэн Г.Тунгалагбуянтын үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг сэргээхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолоор хүчингүй болсон хэлцлийн улмаас бусдад учруулсан хохирлыг барагдуулж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Батс инвест” ХХК /Л.Жавзмаа/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН